



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/78

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 1 дүгээр баг, Төвийн За тоотод байршилтай иргэн Ганзоригийн Цолмонгийн Үйлчилгээний зориулалттай 348м2 газраас “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу иргэн Батболдын Баттөгс /ЕТ89033112/-д “Үйлчилгээ”-ний зориулалтаар 218 м2 газрыг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Өөрийн эзэмшилд үлдэж буй 130 м2 газрыг Үйлчилгээний зориулалтаар иргэн Ганзориг овогтой Цолмонд үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэн (Ганзоригийн Цолмон), (Батболдын Баттөгс) нарт үүрэг болгосугай.

4.Газар эзэмшигч иргэн Ганзоригийн Цолмон, Батболдын Баттөгстэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны А/09 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА